



БИО-АНАГААХ СУДЛААЧ

АХЛАХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Сүүлийн 5 жилийн ажлын тайлан /удирдах ажилтны тамга, гарын үсгээр баталгаажсан байна/;
2. Жилд мэргэжлийн 6-аас доошгүй багц цагийн сургалтад хамрагдсан байх /гэрчилгээ, тодорхойлолтоор баталгаажсан байна/;
3. Сүүлийн 5 жилд тухайн лабораториид 3-аас доошгүй шинэ арга технологи, ашигтай загвар нэвтрүүлсэн байх /гэрчилгээ, тодорхойлолтоор баталгаажсан байна/;
4. Тухайн лабораториид био-анагаах судлаач, техникч наарт жилд 5-аас доошгүй удаа хичээл заасан байх /сургалтын материал, эмнэлгийн сургалтын албаар баталгаажсан байна/;
5. Мэргэжлийн англи хэлний зохих түвшингийн мэдлэгтэй байх /гэрчилгээгээр баталгаажсан байна/;
6. Компьютерийн мэдлэгийн зохих түвшин хангасан /гэрчилгээгээр баталгаажсан байна/;
7. Сүүлийн 5 жилд өгүүлэл, илтгэлийн 4-өөс доошгүй хураангуй нийтлүүлсэн байх /өгүүлэл, илтгэлийн хураангуйн хуулбараар баталгаажсан байна/.

ТЭРГҮҮЛЭХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Ахлах зэрэг хамгаалаад 5 жил тасралтгүй ажилласан байх /мэргэшлийн зэргийн үнэмлэхийн эх хувиар баталгаажсан байна/;
2. Сүүлийн 5 жилийн ажлын тайлан /удирдах ажилтны тамга, гарын үсгээр баталгаажсан байна/;
3. Жилд мэргэжлийн 6-аас доошгүй багц цагийн сургалтад хамрагдсан байх /гэрчилгээ, тодорхойлолтоор баталгаажсан байна/;
4. Сүүлийн 5 жилд тухайн лабораториид 3-аас доошгүй шинэ арга технологи, ашигтай загвар нэвтрүүлсэн байх /гэрчилгээ, тодорхойлолтоор баталгаажсан байна/;

Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн
2020 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн
12 дугаар тогтоолын хавсралт

5. Тухайн лабораторид био-анагаах судлаач, техникч нарт жилд 8-аас доошгүй удаа хичээл заасан байх /сургалтын материал, эмнэлгийн сургалтын албаар баталгаажсан байна/;
6. Мэргэжлийн англи хэлний зохих түвшингийн мэдлэгтэй байх /гэрчилгээгээр баталгаажсан байна/;
7. Компьютерийн зохих түвшний мэдлэгтэй байх /гэрчилгээгээр баталгаажсан байна/ ;
8. Сүүлийн 5 жилд өгүүлэл, илтгэлийн 6-аас доошгүй хураангуй нийтлүүлсэн байх /өгүүлэл, илтгэлийн хураангуйн хуулбараар баталгаажсан байна/.